

## БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ АСУУЛГА

Энэ бүлэгт тухайн иргэний амьдарч буй улс болон харьяалал, боловсролтой холбоотой мэдээллүүд хамаарна.

**Асуулт - G1.** Та одоо аль улсад байнга амьдарч байна вэ? Гадаад улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар амьдарч байгаа иргэн хэд хэдэн улс орон дамжин амьдарч, сурч, ажилласан байж болно. Гадаад улсын нэрийг сонгох хувилбараар программд оруулсан бөгөөд үсгийн дарааллаар байршуулсан. Үүнээс зөвхөн одоо амьдарч буй улсын нэрийг сонгох байдлаар нөхнө.

**Асуулт - G2.** Таны хүйс? Уг асуулт нь Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын зөвлөмжийн дагуу тооллого, судалгаанд тусгаж оруулдаг стандарт асуулт юм. Энэ асуултын хариултыг нөхөхдөө Эрэгтэй - 1, Эмэгтэй - 2 гэсний аль тохирох кодыг нөхнө.

**Асуулт - G3.** Таны нас? Энэ нь мөн адил Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын зөвлөмжийн дагуу тооллого, судалгаанд зайлшгүй тусгаж оруулдаг стандарт асуултын нэг юм. Тэгэхдээ иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, гадаад паспорт, оршин суух үнэмлэх бусад баримт бичигтэйгээ зөрөхгүй байхыг анхаарах хэрэгтэй.

**Асуулт - G4.** Таны иргэний харьяалал? Иргэний харьяаллыг нөхөхдөө Монгол Улс буюу “1”, Гадаад буюу “2”, Харьяалалгүй буюу “3” гэсэн сонголтоос аль тохирохыг кодыг нөхнө.

**Санамж:** Хэрэв та гадаад улсын харьяалалтай эсвэл харьяалалгүй бол энэхүү судалгааг дуусгана.

**Асуулт - G5.** Та [G1] улсад гэр бүлийн хамт амьдарч байна уу? (энэ судалгаанд өрхөөс зөвхөн 1 гишүүн хариулна) Та гэр бүлийн хамт амьдарч байвал Тийм буюу “1”, гэр бүлийн хамт амьдардаггүй бол Үгүй буюу “2” гэсэн кодыг нөхнө. Хэрэв Үгүй гэсэн хариултыг сонгосон бол Асуулт (G8) руу шилжинэ.

**Асуулт - G6.** Тантай хамт амьдарч байгаа гишүүдийн тоо хэд вэ? Гэр бүлийн гишүүн гэж тодорхойлогдсон гишүүдийн тооны нийлбэрээр тодорхойлогдох бөгөөд сонголтуудаас тохирох кодыг нөхнө.

**Асуулт - G7.** Та [G1] улсад хэн хэнтэйгээ амьдарч байна вэ? Судалгаанд хамрагдаж буй иргэн хамт амьдарч буй гэр бүлийн гишүүнийг тодорхойлохдоо “А-Н” гэсэн кодтой сонголтуудаас аль тохирох кодыг нөхнө. Бусад хамаатан буюу “I” гэсэн сонголтод авга, нагац хамаатнууд болон эхнэр/нөхрийн авга, нагац хамаатнууд, тэдгээрийн эхнэр/нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү, эмээ, өвөөг тус тус хамааруулна. Харин “А-I” гэсэн кодтой сонголтуудаас таны хамт амьдарч байгаа хүнийг тодорхойлох хариулт байхгүй бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхнө.

“Эхнэр/ нөхөр – А” Гэрлэсэн болон хамтран амьдарч буй харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг;

“Хүү/ охин – В” Төрсөн болон өргөмөл, дагавар хүү, охиныг;

“Эцэг/ эх – С” Төрсөн болон өргөж авсан, хойд эцэг, эхийг;

“Ах/ эгч/ дүү – D” Өрхийн тэргүүлэгчийн төрсөн ах, эгч, дүү болон өрхийн

тэргүүлэгчийн эцэг, эхийн өргөмөл, дагавар хүү, охин;

“**Хадам эцэг/ хадам эх – E**” Өрхийн тэргүүлэгчийн эхнэр/нөхрийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх;

“**Хүргэн/ бэр – F** Төрсөн болон өргөмөл, дагавар охины нөхөр, хүүгийн эхнэр;

“**Өвөг эцэг/ эмэг эх – G**” Өрхийн тэргүүлэгчийн эмээ, өвөөг;

“**Ач/ зээ– H**” Төрсөн болон өргөмөл, дагавар хүү, охины хүүхдийг;

“**Бусад хамаатан – I**” Өрхийн тэргүүлэгчийн өөрийн авга, нагац хамаатнууд болон эхнэр/нөхрийн авга, нагац хамаатнууд, тэдгээрийн эхнэр/нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү, эмээ, өвөөг;

“**Бусад – X**” Өрхийн тэргүүлэгчтэй төрөл, садны хамааралгүй буюу найз, нөхөд, хамт ажиллагч зэрэг хүнийг хамааруулна.

**Асуулт - G8. Таны эзэмшсэн боловсролын дээд түвшин аль нь вэ?** Энэ асуулт нь таны эзэмшсэн боловсрол буюу хамгийн сүүлд ямар боловсрол эзэмшсэнээр тодорхойлогдоно. Өөрийн боловсролын түвшнийг нөхөхдөө 1-10 гэсэн сонголтуудаас аль тохирох кодыг нөхнө. Хэрэв боловсролгүй буюу “1” гэсэн кодыг нөхсөн тохиолдолд Асуулт (G10) руу шилжинэ.

**Асуулт - G9. Та дээрх боловсролыг аль улсад эзэмшсэн бэ?** “Асуулт- G8”-д хариулсан тухайн боловсролыг аль улсад эзэмшсэн болохыг уг асуулт илтгэнэ. Гадаад улсын нэрийг сонгох хувилбараар программд оруулсан бөгөөд үсгийн дарааллаар байршуулсан. Та тухайн боловсролыг эзэмшсэн улсын нэрийг сонгох байдлаар нөхнө.

**Асуулт - G10. Таны үндсэн мэргэжил юу вэ?** Та өөрийн үндсэн мэргэжлээ тусгайлан үлдээсэн зайд нөхөж тодорхой бичнэ. Жишээлбэл, “багш” гэсэн ерөнхий нэршлээр бус “бага ангийн багш” гэж бичнэ.

**Асуулт - G11. Та дээрх мэргэжлийг аль улсад эзэмшсэн бэ?** Гадаад улсын нэрийг сонгох хувилбараар программд оруулсан бөгөөд үсгийн дарааллаар байршуулсан. Та өөрийн үндсэн мэргэжлийг эзэмшсэн улсын нэрийг сонгох байдлаар нөхнө.

**Асуулт - G12. Таны гэрлэлтийн байдал аль нь вэ?** Доорх тайлбарыг ашиглан харгалзах кодыг нөхнө.

**Гэрлээгүй:** 15 ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

**Гэрлэлт/ Батлуулсан:** Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн гэрлэлтийн баталгаатай хүнийг хамруулна.

**Гэрлэлт/ Батлуулаагүй:** Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй эсвэл хамтран амьдрагч хүнийг хамруулна.

**Салсан/Тусгаарласан:** Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүнийг хамруулна. Гэхдээ албан ажлын улмаас 2 тусдаа амьдарч байгаа хүнийг оруулахгүй.

**Бэлэвсэн:** Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр энд хамруулна

**Асуулт - G13.** Та/танайх ямар орон сууцанд амьдарч байна вэ? Одоогийн амьдарч байгаа сууцыг асууж байгаа бөгөөд сууцны төрлийг бие даасан тохилог сууц (хаус), нийтийн орон сууц, хажуу өрөө, нийтийн байр гэсэн сонголтуудаас аль тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “9” гэсэн кодыг нөхнө.

Амьдарч буй сууцыг аль төрөлд хамааруулахыг доорх хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлав.

**Бие даасан тохилог сууц (хаус).** Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) байна. Үүнд:

- a) Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй;
- b) Орц, туслах өрөө тасалгаа, дээврийн хөндий, зоорины давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууцыг үүнд хамааруулна.
- c) Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй мөн мансардтай болон мансардгүй байж болно.

**Нийтийн орон сууц.** Орон сууцны байшин. Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, судалгаа авах үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрд зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь дэд бүтцийн бүх төрлийн суурь хангамжаар тоноглогдсон, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд:

- a) Цахилгаан, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй;
- b) Сууцны дотор бие засах газартай;
- c) Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй;
- d) Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна.

**Хажуу өрөө.** Бусдын байр сууцанд нэг өрөө, тасалгаанд нь түрээстэй болон түрээсгүйгээр амьдарч байгаа аль ч нөхцөлийг энд хамааруулна.

**Нийтийн байр.** Иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг, олон өрөөтэй, судалгаа авах үед хүн амьдарч байгаа сууцыг нийтийн байранд хамааруулна. Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Нийтийн байр гэдэгт оюутан, сурагчдын дотуур байр, байгууллагын ажиллагчдын байр орно.

а) Оюутан, сурагчдын нийтийн байр. Бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, түүнтэй адилтгах бусад нийтийн байрыг хэлнэ.

б) Ажиллагчдын нийтийн байр. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид хамтран буюу ганц нэгээрээ суухад зориулагдсан нийтийн байрыг хэлнэ.

**Бусад:** Судалгаа авах үед хүн амьдарч байгаа, байнгын бус, түр орогнох, хүн амьдрахад тохиромжгүй байр, талбайг бусад төрөлд хамааруулна. Эдгээрт байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний худаг (траншей), ой мод, уул хад, агуй зэрэг орно.

## БҮЛЭГ II. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Энэ бүлэгт Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн тухайн улсдаа хэдэн жил, сар болж байгаа болон түүнтэй холбогдол бүхий мэдээллийг судална.

**Асуулт - М1.** Та аль аймаг/нийслэл (гадаад улс)-д төрсөн бэ? Аймаг/нийслэл, Гадаад улсын нэрийг сонгох хувилбараар программд оруулсан бөгөөд сонголтуудаас өөрийн төрсөн засаг, захиргааны харьяаллын дагуух аймаг, нийслэл, улсын нэрийг сонгох байдлаар нөхнө.

**Асуулт - М2.** Та [G1] улсад хэдэн оноос хойш амьдарч байна вэ? Оныг сонгох хувилбараар программд оруулсан бөгөөд сонголтуудаас тохирох кодыг нөхнө.

**Асуулт - М3.** М3. Та [G1] улсад албан ёсны оршин суух зөвшөөрөлтэй юу? Албан ёсны зөвшөөрөлтэй гэдэг нь эрх бүхий байгууллагаас олгосон тухайн улсын хилээр нэвтрэх, тодорхой хугацаанд байх зөвшөөрлийг хэлнэ. Та тухайн улсад оршин суух албан ёсны зөвшөөрөлтэй бол Тийм буюу “1” гэсэн хариултыг, зөвшөөрөлгүй бол Үгүй буюу “2” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт – М4.** Та ямар хэлбэрийн оршин суух зөвшөөрөлтэй вэ? Судалгаанд хамрагдаж буй иргэн хариултыг нөхөхдөө Албаны хэргээр буюу “1”, Хувийн хэргээр бол Хөдөлмөр эрхлэх буюу “2”, Гэр бүлийн шалтгаанаар буюу “3”, Суралцах буюу “4”, Цагаачлах буюу “5”, Шашны буюу “6”, гэсэн сонголтуудаас аль тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Хувийн бусад шалтгаанаар бол “9” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт – М5.** Шалгах асуулт Хэрэв асуулт М1-д монголд төрсөн бол асуулт М7 руу, үгүй бол М6 руу шилжинэ.

**Асуулт – М6.** Та Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар амьдарч байсан уу? Та Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар амьдарч байсан бол Тийм буюу “1” гэсэн хариултыг, Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар амьдарч байгаагүй бол Үгүй буюу “2” гэсэн кодыг нөхнө. Хэрэв Үгүй гэсэн хариултыг сонгосон тохиолдолд Асуулт (М17) руу шилжинэ.

**Асуулт – М7.** Та хамгийн сүүлд хэзээ Монгол Улсаас явсан бэ? Оныг сонгох хувилбараар программд оруулсан бөгөөд сонголтуудаас тохирох кодыг нөхнө.

**Асуулт – М8.** Та Монгол Улсаас явахын өмнө аль аймаг/нийслэлд амьдарч байсан бэ? Аймаг/нийслэлийн нэрийг сонгох хувилбараар программд оруулсан бөгөөд уг асуултад хариулахдаа гадаад улс руу явахаас өмнө амьдарч байсан аймаг/нийслэлийн нэрийг сонгох байдлаар нөхнө.

**Асуулт – М9. Та [G1] улсад ирсэн үндсэн зорилго нь юу вэ?** Гадаад шилжих хөдөлгөөнд оролцож буй шалтгаанаар нь дараах байдлаар ангилна. Суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зорилгоор шилжин явсан бол Суралцах буюу “1”, Хувиараа ажиллах буюу “2”, Гэр бүлийн шалтгаанаар оршин суух буюу “3”, Суурьших буюу “4”, Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах буюу “5”, Албан томилолтоор ажиллах буюу “6”, Эмчлүүлэх буюу “7”, Цагаачлахаар буюу “8” гэсэн хариултуудаас аль тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “9” гэсэн кодыг нөхнө.

**Суралцах:** Монгол болон гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагын тэтгэлэг, оюутан солилцоогоор, түүнчлэн хувиараа гадаадын их, дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургууль, хэлний курст суралцагчид, мөн дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны хөдөлмөр эрхэлж байгаа бол энэ ангилалд хамааруулна.

**Хувиараа ажиллах:** Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах болон албан томилолтоор ажиллахаас бусад тохиолдлоор хувиараа эсвэл хувь хүнээр зуучлуулан ажил эрхэлж байгаа бол энэ ангилалд хамрагдана. Тухайлбал, гадаад улсад суугаа хамаатан садан, найз нөхөд гэх мэт хэн нэгний урилгаар гадаад руу явсан боловч гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс орно.

**Гэр бүлийн шалтгаанаар оршин суух:** Гадаадын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн Монгол Улсын иргэн, түүний 16 хүртэлх насны Монгол Улсын харьяат хүүхэд болон гадаад улсад суралцах, хөдөлмөр эрхлэх, байнга оршин суух болон бусад шалтгаанаар оршин суугаа иргэний эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхдүүдийг энэ ангилалд хамааруулна.

**Суурьших:** Гадаад улсад суурьшин амьдарч буй болон цаашид суурьшин амьдрахаар төлөвлөж буй бол энэ ангилалд багтана.

**Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах:** Ажиллах хүч гадаад улсад зуучлах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагаар зуучлуулан гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр болон үйлдвэрийн дадлагажигчаар ажиллахаар явсан хүмүүсийг хамааруулна<sup>5</sup>.[\[1\]](#)

**Албан томилолтоор ажиллах:** Гадаад улсад Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газрууд болон олон улсын байгууллагад ажиллаж буй бол энэ ангилалд хамруулна. Харин эдгээр хүмүүсийн гэр бүлийн гишүүд нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух гэсэн ангилалд орно. Харин Афганистан, Ирак, Сьерра Леон болон бусад улсад Батлан хамгаалах яам (БХЯ)-ны журмаар явсан иргэдийг хамааруулахгүй.

**Асуулт – М10. Та анх гадаад улс руу явахдаа зардлаа хэрхэн шийдсэн бэ?** (Хамгийн ихдээ 3 хариулт сонгоно.) Та уг асуултад хариулахдаа нэгээс дээш хариулт сонгож болох ба гадаад улсад анх ирэх үеийн зардлаа хэрхэн шийдсэн гэдгийг тодорхойлох кодыг нөхнө. Үүнд: Хуримтлалаасаа гаргасан буюу “А”, Орон сууц бусад зүйлээ борлуулсан буюу “В”, Бусдаас авсан хандив, тусламж буюу “С”, Тэтгэлэг буюу “D”, Буяны байгууллагын тусламж буюу “E”, Зээл авсан буюу “F” гэсэн

---

<sup>5</sup> Ажиллах хүч гадаадад, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн дагуу

сонголтууд өгөгдсөн байна. Эдгээрээс бусад бол Бусад буюу “Х” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт – М11.** Та [G1] улсад ирээд байр сууриа олтол хэр хугацаа зарцуулсан бэ? Өөрийн байр сууриа олох хүртэл зарцуулсан хугацааг 1-3 сар буюу “1”, 4-6 сар буюу “2”, 7-12 сар буюу “3”, 1-2 жил буюу “4”, 3, түүнээс дээш жил буюу “5” гэсэн сонголтуудаас тохирох кодыг нөхнө.

“**Байр сууриа олтол**” гэдэгт гадаад улс руу явсан өөрийн зорилгодоо хүртэл хэрэглээгээ хангахуйц тогтмол орлоготой, ажил хөдөлмөр хийх, сурч боловсрох боломжтой, үр хүүхэд сурах нөхцөлөөр хангагдсан байхыг ойлгоно.

**Асуулт - М12.** Танд [G1] улсад ирсний дараа хүндрэл, бэрхшээлүүд тулгарч байсан уу? Танд тухайн улсад ирсний дараа ямар нэгэн хүндрэл, бэрхшээл тулгарч байсан бол Тийм буюу “1”, ямар нэгэн хүндрэл, бэрхшээл тулгарч байгаагүй бол Үгүй буюу “2” гэсэн кодыг нөхнө. Хэрэв Үгүй гэсэн хариултыг сонгосон тохиолдолд Асуулт (М14) руу шилжинэ.

**Асуулт - М13.** Танд ямар хүндрэл, бэрхшээлүүд тулгарсан бэ? (Хамгийн ихдээ 3 хариулт сонгоно.) Та уг асуултад хариулахдаа нэгээс дээш хариулт сонгож болох ба Хэлний бэрхшээл, Ажил олдохгүй байх, Ажиллах зөвшөөрөлгүй, Мэдээлэл олж авах арга замаа мэдэхгүй, Хүүхдийн сургууль, цэцэрлэг, Сургалтын төлбөр, Оршин суух зөвшөөрөл, Орон байр олдохгүй байх, Ялгаварлан гадуурхалт(арьс өнгө, шашин шүтлэг, гарал үүсэл, хүйс гэх мэт) гэсэн сонголтууд өгөгдсөн бөгөөд таны хувьд дээрх бэрхшээлүүдээс аль нь тулгарч байсныг тухайн сонголтод харгалзах кодыг нөхнө. Эдгээрээс бусад бэрхшээл тулгарч байсан бол Бусад буюу “9” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - М14.** [G1] улсад ирснээр Таны амьдралд ямар нэгэн эерэг болон сөрөг нөлөө гарсан уу? Тухайн улсад ирснээр танд ямар нэг эерэг, сөрөг нөлөө гарсан бол Тийм буюу “1”, ямар нэг эерэг, сөрөг нөлөө гарч байгаагүй бол Үгүй буюу “2” гэсэн кодыг нөхнө. Хэрэв Үгүй гэсэн хариултыг сонгосон тохиолдолд Асуулт (М16) руу шилжинэ.

**Асуулт - М15.** Тийм бол ямар эерэг болон сөрөг нөлөө гарсан бэ? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба эерэг болон сөрөг гэсэн хариултын хоёр хэсэгтэй бөгөөд 1-р хэсэгт А-F хүртэлх эерэг нөлөө, 2-р хэсэгт А-G хүртэлх сөрөг нөлөөг илэрхийлэх сонголтууд өгөгдсөн байна. Тохирох хариултын кодыг нөхөж, бусад нөлөөг нэмж нэрлэх бол Бусад буюу “Х” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - М16.** Шалгах асуулт Та (М8-М15) асуултад хариулсан бол дараагийн бүлэг III руу шилжинэ.

**Асуулт - М17.** [G1] улсад оршин сууснаас хойш Танд Монгол Улсын төрөөс үзүүлж байгаа аливаа үйлчилгээг авахад хүндрэл, бэрхшээл тулгарсан уу? Танд тухайн улсад оршин сууснаас хойш МУ-ын төрөөс үзүүлж байгаа аливаа үйлчилгээ авахад хүндрэл, бэрхшээл тулгарсан бол ТИЙМ буюу “1” гэсэн хариултыг, ҮГҮЙ бол “2” гэсэн кодыг нөхнө. Хэрэв ТИЙМ гэсэн хариулт сонгосон бол ямар хүндрэл, бэрхшээл тулгарсныг тусгайлан үлдээсэн зайд бичнэ.

### **БҮЛЭГ III. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**



Санамж: Энэ бүлэгт цалин хөлстэй ажил/бизнес эрхэлсэн үү? гэсэн ойлголт гарч ирэх ба бизнес эрхлэх гэдэгт орлогоо нэмэгдүүлэх зорилготой хийсэн бүх төрлийн ажлыг хамааруулж ойлгоно. Зөвхөн ямар нэгэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг хэлээгүй юм. Жишээлбэл: фермер, мал ахуй эрхлэх, газар тариалан эрхлэх болон бизнес эрхлэх нь бүгд орно.

**Асуулт - L1** Та одоо ажил эрхэлж байна үү? Энэ асуулт нь ямар нэгэн цалин хөлс, орлого олох зорилгоор ажил эрхэлж байгаа эсэхийг тодорхойлох зорилготой асуулт юм. Цалин хөлстэй хөдөлмөр эрхэлсэн бол Тийм буюу “1”, эрхлээгүй бол Үгүй буюу “2” гэсэн кодыг нөхөж, Асуулт “L8” руу шилжинэ.

**Асуулт - L2.** Та хэдэн ажил эрхэлж байна вэ? Та өөрийн эрхэлж буй ажлын тоог тохирох нүдэнд нөхнө

**Асуулт - L3.** Та ямар мэргэжлийн ажил хийж байна вэ? (1-ээс олон ажилтай бол илүү орлого олдог 1 ажлыг бичнэ үү Өөрийн эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагааг тусгайлан үлдээсэн зайд бичнэ.

**Асуулт - L4.** Таны эрхэлдэг үндсэн ажил (байгууллага)-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ? (1-ээс олон ажилтай бол илүү орлого олдог 1 ажлын тохирох салбарыг сонгоно уу) Эрхэлдэг ажил (байгууллага)-ын үйл ажиллагааны чиглэлийг тодруулахдаа үндсэн ажлын хувьд нөхөх бөгөөд эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу “1-20” гэсэн кодтой сонголтуудаас аль тохирохыг сонгож хариулна. Эдгээрээс бусад ажил, үйл ажиллагаа эрхэлдэг бол Бусад буюу “99” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - L5.** Таны ажлын байдал юу вэ? Хариултыг нөхөхдөө Байнгын (гэрээний хугацаа тогтмол) буюу (1), Түр (гэрээний хугацаа 3 ба түүнээс дээш сар) буюу “2”, Тохиолдлын (гэрээний хугацаа 3 сар хүртэл) буюу “3”, бусад байдлыг нэмж нэрлэх бол Бусад буюу “9” гэсэн кодыг нөхнө.

Аль төрөлд хамааруулахыг ойлголт, тодорхойлолт бүлгийн “Хөдөлмөр эрхлэлтийн статус” хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлав.

**Асуулт - L6.** Та ажлын нөхцөлөө хэлнэ үү? Хөдөлмөрийн нөхцөлийг Хэвийн буюу “1”, Хэвийн бус буюу “2” гэсэн сонголтоос аль тохирох кодыг нөхнө.

Хөдөлмөрийн хэвийн ба хэвийн нөхцөлийг дараах байдлаар ойлгоно.

**Хэвийн нөхцөл** - Үйлдвэрлэлийн ажлын байрны орчны болон хөдөлмөрийн үйл ажиллагааны хүчин зүйлс нь ажилтны эрүүл мэндэд нөлөөлдөггүй буюу тэдгээрийн хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээнээс хэтрээгүй нөхцөлийг хэвийн нөхцөл гэнэ.

**Хэвийн бус нөхцөл** - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын хүрээнд сөрөг нөлөөллийг нь арилгах боломжгүй, хөдөлмөрийн стандартад нийцээгүй ажлын байрны нөхцөлийг хэвийн бус нөхцөл гэнэ<sup>6</sup>.

**Асуулт - L7.** Та 7 хоногт тогтмол хэдэн цаг ажилладаг вэ? Өөрийн 7 хоногт тогтмол хэдэн цаг ажилладаг болохыг дараах бүлэглэсэн хугацаанаас сонгоно. Үүнд: 1-14 цаг буюу “1”, 15-29 цаг буюу “2”, 30-34 цаг буюу “3”, 35-39 цаг буюу “4”, 40-

<sup>6</sup> <https://estandard.gov.mn/standard/reader/4511#0-nvvsacckeewytsww.jpg>

48 цаг буюу “5”, 48, түүнээс дээш цаг буюу “6” гэсэн сонголтуудаас тохирох кодыг нөхөн Асуулт “L11” рүү шилжинэ.

**Асуулт - L8.** Та ажил хийгээгүй байгаа гол шалтгаанаа хэлнэ үү? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба ажил хийгээгүй байгаа гол шалтгааныг Ажиллах зөвшөөрөл байхгүй буюу “1”, Хэлний бэрхшээлээс болж буюу “2”, Мэргэжил, ур чадвар дутагдсан буюу “3”, Хүүхэд, өндөр настан, өвчтөн асрах буюу “4”, Эрүүл мэндийн байдлаас буюу “5”, Тэтгэвэрт гарсан буюу “6”, Ажил хайгаад олдохгүй буюу “7”, гэсэн сонголттой хариултуудаас аль тохирох кодыг нөхөх ба эдгээрээс бусад шалтгаантай бол Бусад буюу “9” гэсэн кодыг нөхөн, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт – L9.** Таны орлогын эх үүсвэр юу вэ? (Хамгийн ихдээ 3 хариулт сонгоно.) Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба Цалин хөлс буюу “А”, Тэтгэвэр буюу “В”, Тэтгэмж буюу “С”, Бизнесийн орлого буюу “D”, Хувь хүн/өрхөөс ирдэг тусламж гуйвуулга буюу “Е”, Өмчөө бусдад түрээслүүлсний орлого буюу “F”, Хадгаламжийн хүү, хувьцааны ноогдол ашиг буюу “G” гэсэн сонголтууд өгөгдсөн бөгөөд тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад эх үүсвэртэй бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт – L10.** Таны сарын дундаж орлого хэд вэ? Сарын дундаж орлогын хэмжээгээр тодорхойлж нөхөх ба мөнгөн дүнг тухайн улсын мөнгөн тэмдэгтээр бичнэ Бусад бол бусад бичих хэсэгт мөнгөн тэмдэгтийг бичнэ. Хэмжээг тэмдэглэхдээ цэг болон тэмдэгтийг хэрэглэхгүй. (программд дээд, доод хязгаарыг заасан).

**Асуулт - L11.** Таны сарын орлого хэрэглээндээ хангалттай хүрдэг үү? Сарын орлого нь амьдралын хэрэгцээнд тань хангалттай хүрдэг бол Тийм буюу “1”, амьдралын хэрэгцээнд тань хангалттай хүрдэггүй бол Үгүй буюу “2” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - L12.** Та аль нэг улсын эрүүл мэндийн даатгалд хамрагддаг үү? Та аль нэг улсын эрүүл мэндийн даатгалд хамрагддаг бол Тийм буюу “1”, кодыг сонгоно. Үгүй бол “2” кодыг нөхнө. Хэрэв Үгүй гэсэн хариултыг сонгосон тохиолдолд Асуулт (L14) руу шилжинэ.

**Асуулт - L13.** Хэрэв хамрагддаг бол аль улсын эрүүл мэндийн даатгалд хамрагддаг вэ? Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг бол аль улсад хамрагддаг эсэхийг тодорхойлох ба "Монгол Улсын" эрүүл мэндийн даатгалд хамрагддаг бол “1”, өөрийн "Оршин суугаа улсын" эрүүл мэндийн даатгалд хамрагддаг бол “2” кодыг нөхнө. Эдгээрээс "Бусад гадаад улсын" эрүүл мэндийн даатгалд хамрагддаг бол “3” кодыг нөхнө.

**Асуулт - L14.** Та аль нэг улсын нийгмийн даатгалд хамрагддаг үү? Нийгмийн даатгал нь иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх тухай арга хэмжээ юм. Тухайн иргэн нь аль нэг улсын нийгмийн даатгалд хамрагддаг бол Тийм буюу “1” кодыг нөхнө. Харин нийгмийн даатгалд хамрагддаггүй бол Үгүй буюу “2” кодыг нөхнө. Хэрэв Үгүй гэсэн хариултыг сонгосон тохиолдолд Асуулт (L16) руу шилжинэ.



**Асуулт - L15.** Хэрэв хамрагддаг бол аль улсын нийгмийн даатгалд хамрагддаг вэ? Тухайн иргэн нь нийгмийн даатгалд хамрагддаг бол аль улсад хамрагддаг эсэхийг тодорхойлох ба Монгол Улсын нийгмийн даатгалд хамрагддаг бол Монгол Улс буюу “1”, өөрийн Оршин суугаа улсын нийгмийн даатгалд хамрагддаг бол “2” кодыг нөхнө. Эдгээрээс Бусад гадаад улсын нийгмийн даатгалд хамрагддаг бол “3” кодыг нөхнө.

**Асуулт - L16.** Шалгах асуулт Хэрэв асуулт М6-д Монгол Улсад амьдарч байгаагүй бол бүлэг IV рүү шилжинэ.

**Асуулт – L17.** Та Монгол Улсад байхдаа хамгийн сүүлд ямар мэргэжлээр ажиллаж байсан бэ? Та аль нэг улс руу явахаасаа өмнө Монгол улсад ямар мэргэжлээр хамгийн сүүлд ажиллаж байсныг тодруулах ба үүнийг тусгайлан үлдээсэн зайд тодорхой бичнэ.

#### БҮЛЭГ IV. ГҮЙВУУЛГА, ИЛГЭЭМЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Энэ бүлэг нь хоёр хэсгээс бүрдэх ба гадаад улсад байгаа иргэн Монгол Улсад байгаа гэр бүлийн гишүүнтэйгээ ихэвчлэн ямар зорилгоор холбогддог, сүүлийн 12 сард хэдий хэмжээний мөнгөн гуйвуулга илгээсэн, ингэхдээ ихэвчлэн ямар үйлчилгээг ашигладаг, тулгардаг бэрхшээлүүд, хүлээн авсан гуйвуулгын ашиглалтын талаарх асуултууд багтсан.

##### **IV (а). Мөнгөн гуйвуулгын тухай**

**Асуулт - S1.** Та Монгол Улс руу ихэвчлэн хэнтэй холбогддог вэ? Та Монгол Улсад оршин суугаа хэн нэгэнтэй холбогддог бол тухайн хүнийг тодорхойлох кодыг нөхнө. Үүнд: Эхнэр/нөхөр бол “1”, Эцэг эх/Хадам эцэг эх бол “2”, Хүү охин/ хүргэн бэр/ач зээ бол “3”, Эмээ Өвөө бол “4”, Ах/эгч/дүү бол “5”, Үүнээс бусад хамаатан бол Бусад хамаатан буюу “6” гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “9” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - S2.** Та сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс руу мөнгөн гуйвуулга, эсвэл мөнгөн бус илгээмж явуулсан уу? Уг асуултад хариулахдаа та сүүлийн 12 сард Монгол Улс руу мөнгөн гуйвуулга, эсвэл мөнгөн бус илгээмж явуулсан бол Тийм, аль алиныг нь буюу “1”, Тийм, зөвхөн мөнгөн гуйвуулга буюу “2”, Тийм, зөвхөн мөнгөн бус илгээмж буюу “3” гэсэн сонголтуудаас тохирох кодыг нөхөх ба “3” гэсэн кодыг сонгосон тохиолдолд Асуулт (S7) руу шилжинэ. Харин та сүүлийн 12 сард Монгол Улс руу мөнгөн гуйвуулга, эсвэл мөнгөн бус илгээмж огт явуулаагүй бол Огт үгүй буюу “4” гэсэн кодыг нөхөөд Асуулт (S10) руу шилжинэ.

**Асуулт - S3.** Та мөнгөн гуйвуулгыг ихэвчлэн ямар зорилгоор явуулдаг вэ? Уг асуултад хариулахдаа хамгийн ихдээ 3 хариулт сонгоно. Та мөнгөн гуйвуулгыг ихэвчлэн ямар зорилгоор явуулдаг болохыг “А-Н,Х” гэсэн хариултуудаас тохирох кодуудыг сонгох ба өрхийн хэрэглээний хүрээнд Өдөр тутмын хэрэгцээнд буюу “А”, Сургалтын төлбөр буюу “В”, Эмчилгээнд буюу “С”, Өр, зээлээ барагдуулах буюу “D”, өрхийн хөрөнгө оруулалтын хүрээнд Газар худалдаж авах буюу “Е”, Байр, сууц худалдаж авах буюу “F”, Хадгалах буюу “G”, Өрхийн аж ахуй эрхлэх буюу “Н”, харин Өөрийн хадгаламж буюу “I”, Бизнесийн үйл ажиллагаанд бол “J” гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - S4.** Монгол Улс руу мөнгөн гуйвуулга илгээхдээ ихэвчлэн ямар үйлчилгээг ашигладаг вэ? Банк, ББСБ, Хувь хүн, гэсэн мөнгөн гуйвуулгын

үйлчилгээний сувгуудаас аль тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “9” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - S4a.** Монгол Улс руу сүүлийн 12 сарын хугацаанд хэдэн удаа мөнгөн гуйвуулга илгээсэн бэ? Та сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс руу хэдэн удаа мөнгөн гуйвуулгын илгээснийг дөрвөлжин нүдэнд нөхнө.

**Асуулт - S5.** Монгол Улс руу сүүлийн 12 сарын хугацаанд ойролцоогоор хэдий хэмжээний мөнгөн гуйвуулга илгээсэн бэ? Та сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс руу явуулсан мөнгөн гуйвуулгын хэмжээг тухайн улсын мөнгөн тэмдэгтээр бичнэ. Бусад бол бусад бичих хэсэгт мөнгөн тэмдэгтийг бичнэ. Хэмжээг тэмдэглэхдээ цэг болон тэмдэгтийг хэрэглэхгүй. (программд дээд, доод хязгаарыг заасан).

**Асуулт - S6.** Та сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс руу ямар төрлийн мөнгөн бус илгээмж явуулсан бэ? Та сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс руу ямар төрлийн илгээмж явуулсан болохыг тодорхойлох дараах хариултуудаас сонгоно. Үүнд: Хүнсний бүтээгдэхүүн буюу “А”, Гутал, хувцас буюу “В”, Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл буюу “С”, Эм, витамин, гоо сайхны бүтээгдэхүүн буюу “D”, Машин буюу “E”, Гар утас, таблет, компьютер буюу “F” гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - S7.** Таны сүүлийн 12 сарын хугацаанд Монгол Улс руу явуулсан дээрх мөнгөн бус илгээмжийн мөнгөн дүн ойролцоогоор хэд болох вэ? Та Монгол улс руу явуулсан мөнгөн бус илгээмжийн хэмжээг тухайн улсын мөнгөн тэмдэгтээр бичнэ. Бусад бол бусад бичих хэсэгт мөнгөн тэмдэгтийг бичнэ. Хэмжээг тэмдэглэхдээ цэг болон тэмдэгтийг хэрэглэхгүй. (программд дээд, доод хязгаарыг заасан).

**Асуулт – S8.** Таны Монгол Улс руу гуйвуулсан мөнгө болон мөнгөн бус илгээмжийг хэн хүлээн авдаг вэ? (Хамгийн ихдээ 3 хариулт сонгоно.) Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба таны Монгол Улс руу гуйвуулсан мөнгө болон мөнгөн бус илгээмжийг хүлээж авдаг хүн нь тантай ямар холбоотой болохыг тодорхойлох хариултын кодыг нөхнө. Үүнд: Үүнд: Эхнэр/нөхөр бол “А”, Эцэг эх/Хадам эцэг эх бол “В”, Хүү охин/ хүргэн бэр/ач зээ бол “С”, Эмээ Өвөө бол “D”, Ах/эгч/дүү бол “E”, Үүнээс бусад хамаатан бол Бусад хамаатан буюу “F” гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - S9.** Дээрх илгээмж, гуйвуулгыг Монгол руу явуулахад бэрхшээл тулгардаг уу? Тийм бол ямар бэрхшээл байна вэ? Илгээсэн илгээмж, мөнгөн гуйвуулгыг явуулахад бэрхшээл тулгардаг бол Шимтгэл өндөр буюу “1”, Хугацаа урт буюу “2”, Алдагдах эрсдэл өндөр/найдваргүй буюу “3” гэсэн сонголтоос аль тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “4” гэсэн кодыг нөхнө. Бэрхшээл тохиолдож байгаагүй тохиолдолд “5” гэсэн кодыг нөхнө.

#### **IV (b). Хөрөнгө оруулах боломж**

**Асуулт - S10.** Монгол Улсдаа хөрөнгө оруулах боломжийн талаар Та мэдэх үү? Та хөрөнгө оруулах боломжийн талаар мэддэг бол Тийм буюу “1”, кодыг сонгоно. Үгүй бол “2” кодыг нөхөж Бүлэг (V) руу шилжинэ.

**Асуулт - S11.** Монгол Улсдаа хөрөнгө оруулах боломжийн талаарх мэдээллийг хэрхэн олж авдаг бэ? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба та Монгол Улсдаа хөрөнгө оруулах боломжийн талаарх мэдээллийг хаанаас олж авсан талаар дараах хариултуудаас сонгоно. Үүнд: Санхүүгийн үйлчилгээнд бол “А”, Төрийн

байгууллагууд бол “В”, Нийгмийн сүлжээ бол “С”, Веб хуудас бол “D”, Найзууд, гэр бүлийн гишүүдээс бол “E”, Зар сурталчилгаа бол “F”, Үзэсгэлэн худалдаа бол “G” гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - S12.** Таны бодлоор Монгол Улсад ямар хэлбэрээр хөрөнгө оруулах боломжууд байна вэ? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба дараах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд: “Засгийн газрын үнэт цаас худалдаж авах” бол “A”, “Хувьцаа худалдаж авах” бол “B”, “Аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах” бол “C”, “Дангаараа болон бусадтай хамтран аж ахуйн нэгж байгуулах замаар” бол “D”, Өрхийн бизнест бол “E”, Мэдэхгүй” бол “F” гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - S13.** Танд ирэх 24 сарын хугацаанд Монгол Улсдаа хөрөнгө оруулах төлөвлөгөө байна уу? Ирэх 2 жилийн хугацаанд Монгол Улсдаа хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй эсэхийг тодруулах ба та “Тийм”, “Үгүй” гэсэн хариултын аль нэгийг сонгон кодыг нөхнө. Хэрэв Үгүй гэсэн хариултыг сонгосон тохиолдолд Бүлэг (V) руу шилжинэ.

**Асуулт - S14.** Ямар хэлбэрээр хөрөнгө оруулахаар төлөвлөж байна вэ? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба та дээрх асуулт (S13)-т Тийм гэж хариулсан бол Монгол Улсдаа ямар хэлбэрээр хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй байгаагаа дараа хариултуудаас сонгон кодыг нөхнө. Үүнд: “Засгийн газрын үнэт цаас худалдаж авах” бол “A”, “Хувьцаа худалдаж авах” бол “B”, “Аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах” бол “C”, “Дангаараа болон бусадтай хамтран аж ахуй нэгж байгуулах замаар бол “D”, эдгээрээс бусад бол “X”, шийдээгүй бол “Y”, Мэдэхгүй” бол “Z” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - S15.** Аль салбарт хөрөнгө оруулахаар төлөвлөж байна вэ? (тэргүүлэх 3 салбарыг сонгоно уу) Та аль салбарт хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй байгаагаа дараах хариултуудаас сонгоно. Үүнд эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу “A-T” гэсэн кодтой сонголтууд өгөгдсөн ба эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхнө.

## БҮЛЭГ V. ИРЭЭДҮЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Судалгаанд оролцсон иргэн Монгол Улсдаа эргэн ирэх үед төр засгийн зүгээс нэн түрүүнд ямар асуудлыг шийдвэрлээсэй хэмээн хүсдэг талаарх хүлээлт, гадаад улсад амьдарснаар эх орондоо ямар хувь нэмэр оруулдаг, ер нь монголчууд гадаад улсад олноороо амьдарснаар Монгол Улсад ямар сөрөг үр дагавартай талаарх хариулагчийн санаа бодлыг тандан судлах нээлттэй асуулт багтсан.

**Асуулт - F1.** Танд Монгол Улс руу буцах төлөвлөгөө байгаа юу? Та Монгол руу буцах төлөвлөгөө байгаа бол “Тийм буюу 1”, гэсэн хариултыг сонгон дараагийн асуултад хариулна. Харин “Үгүй” буюу “2” кодыг нөхсөн тохиолдолд Асуулт (F8) руу шилжинэ.

**Асуулт - F2.** Хэдий хугацааны дараа буцах бодолтой байна вэ? Та Монгол Улс руу буцах төлөвлөгөөтэй бол хэдий хугацааны дараа буцах бодолтой байгаагаа “1-6” хариултуудаас тохирох кодыг нөхнө. Үүнд: 1 жилийн дотор буюу “1”, 1-2 жил буюу “2”, 2-3 жил буюу “3”, 3-4 жил “4”, 5, түүнээс дээш жил буюу “5”, Тодорхойгүй буюу “6” гэсэн хариултуудаас тохирох кодыг нөхнө.

**Асуулт - F3.** Буцах шийдвэрийг гаргахад нөлөөлсөн гол шалтгаан нь юу вэ? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба Зорилгоо биелүүлж чадсан буюу “А”, Эрүүл мэндийн байдлаас буюу “В”, Визний зөвшөөрлөөс буюу “С”, Ар гэрийн гачигдлаар буюу “D”, Гэрлэлтээ цуцлуулснаас буюу “E”, Гэр бүлийнхнийхээ хүсэлтээр буюу “F”, Төрсөн нутагтаа суурьших буюу “G” шалтгаануудаас тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - F4.** Монгол Улсад очоод юу хийх төлөвлөгөөтэй байна вэ? Монгол Улсад очоод юу хийх төлөвлөөтэй байгаагаа Цалин хөлстэй ажиллах буюу “А”, Бизнес эрхлэх буюу “В”, Шийдээгүй байгаа буюу “С”, Бусад буюу “X” гэсэн хариултуудаас сонгох ба Шийдээгүй байгаа буюу “С” эсвэл Бусад буюу “X” кодыг нөхсөн тохиолдолд Асуулт (F6) руу шилжинэ.

**Асуулт - F5.** Монгол Улсад очоод аль салбарт ажил, хөдөлмөр эрхлэхээр төлөвлөж байна вэ? Та Монгол Улсад очоод аль салбарт ажил, хөдөлмөр эрхлэхээр төлөвлөж байгаагаа эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу “1-20” гэсэн кодтой сонголтуудаас аль тохирохыг сонгож харгалзах зодыг нөхнө. Эдгээрээс бусад ажил, үйл салбарт ажил, хөдөлмөр эрхлэхээр төлөвлөж байгаа бол Бусад буюу “99” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - F6.** Таныг Монгол Улсад очиход юуг нэн түрүүнд шийдвэрлээсэй гэж та хүсэж байна вэ? Уг асуултыг Ажлын байраар хангах буюу “А”, Бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх буюу “В”, Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээг сайжруулах буюу “С”, Эрүүл тав тухтай амьдрах орчин буюу “D”, Хүнсний аюулгүй байдлыг хангах “E”, Агаарын бохирдлыг бууруулах буюу “F”, Улс төр тогтвортой байх буюу “G”, Эдийн засаг тогтвортой байх буюу “H”, Тоног төхөөрөмжийг татварын хөнгөлөлтөөр оруулах боломжийг бүрдүүлэх буюу “I”, Хөнгөлөлттэй зээл, тусламж үзүүлэх буюу “J”, гэсэн сонголтоос аль тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад шийдвэрлэх асуудал бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - F7.** Та Монгол Улсдаа очвол аль аймаг/нийслэлд амьдрах вэ? Аймаг/нийслэлийн нэрийг сонгох хувилбараар программд оруулсан бөгөөд уг асуултад хариулахдаа гадаад улс руу явахаас өмнө амьдарч байсан аймаг/нийслэлийн нэрийг сонгох байдлаар нөхнө.

**Асуулт - F8.** Таны амьдарч буй улсаас Монгол Улсад хамгийн түрүүнд нэвтрүүлээсэй гэж хүсэж буй шинэлэг санаа юу вэ? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба энэ асуулт нь таны саналыг тодруулах зорилготой. Таны амьдарч буй улсын ямар нэгэн үйл ажиллагаа болон бусад зүйлүүдээс Монгол Улсад хэрэгжүүлэхийг хүсэж буй санааг Дэд бүтцийн салбарын хөгжил буюу “А”, Ур чадвар, бүтээмжийн үнэлгээ буюу “B”, Үйлчилгээний соёл буюу “C”, Үйлдвэрлэлийн технологи буюу “D”, Мэдэхгүй бол “Z” гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - F9.** Та гадаад улсад амьдарснаар Монгол Улсад ямар хувь нэмэр оруулж байна вэ? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба та гадаад улсад амьдарснаар Монгол Улсад ямар хувь нэмэр оруулж буйг дараах өгөгдсөн хариултуудаас сонгоно. Үүнд: Микро түвшин буюу өрхийн амьжиргааг дээшлүүлэх буюу “А”, Ур чадвартай боловсон хүчинтэй болгох буюу “B”, Шинэлэг санаа, бизнес,

үйлчилгээ нэвтрүүлэх буюу “С”, Мэдэхгүй бол “Z”, гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - F10.** Монгол Улсын иргэд нь гадаад улсад амьдарснаар Монгол Улсад ямар сөрөг үр дагавартай гэж бодож байна вэ? Уг асуултад нэгээс олон хариулт сонгож болох ба та гадаад улсад амьдарснаар Монгол Улсад ямар сөрөг үр дагавартай болохыг дараах өгөгдсөн хариултуудаас сонгоно. Үүнд: Хүн амын өсөлт удаашрах буюу “А”, Монгол хүн гадаад улсын соёл, ахуйд уусах буюу “В”, Ажиллах хүчний хомсдол үүсэх буюу “С”, Гэр бүл салалт нэмэгдэх буюу “D”, Чадвартай боловсон хүчнээ алдах буюу “Е”, Эх хэл, соёл уламжлал мартагдах буюу “F”, Мэдэхгүй бол “Z” гэсэн кодыг нөхнө. Эдгээрээс бусад бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - F11.** Буцахгүй гэсэн шийдвэр гаргахад нөлөөлсөн гол шалтгаан нь юу вэ? Үүнд эдийн засаг, нийгмийн, улс төр зэрэг хамаарч, татах хүчин зүйлд өөр улсад тэмүүлэх шалтгаанууд хамаарна. Амьдралын нөхцөл энд илүү буюу “А”, Монгол Улсад амьдрах баталгаа алга буюу “В”, Өрөө төлж дуусаагүй буюу “С”, Хүүхдүүдийн ирээдүйг бодож буюу “D”, Гадаадын иргэнтэй гэрлэсэн буюу “Е”, гэсэн сонголтоос аль тохирох кодыг нөхнө. Эдгээрээс бусад шийдвэрлэх асуудал бол Бусад буюу “X” гэсэн кодыг нөхөж, хариултыг тодотгож бичнэ.

**Асуулт - F12.** Танд амьдарч буй улсынхаа иргэн болох бодол байгаа юу? Та амьдарч буй улсынхаа иргэн болох хүсэлтэй бол ТИЙМ буюу “1” гэсэн хариултыг, ҮГҮЙ бол “2”, Мэдэхгүй бол “3”, Хариулахгүй бол “4” гэсэн кодыг нөхнө.

**Асуулт - F13.** Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай гэж Та бодож байна үү? Та тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байвал ТИЙМ буюу “1” гэсэн хариултыг, ҮГҮЙ бол “2” гэсэн кодыг нөхнө. Хэрэв ТИЙМ гэсэн хариулт сонгосон бол ямар хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатайг тусгайлан үлдээсэн зайд бичнэ.